

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар
2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШҮ
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ									
1.1.	Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, ерөнхий боловсролын салбарын богино, дунд хугацааны арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	Батлагдсан төсвийн хүрээнд	-	-	-		1. Ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициент, нэг ээлжээр хичээллэх сургуулийн боломжийг судалж, холбогдох тооцооллыг гаргасан. 2. Нэг ээлжээр хичээллэх сургуулийн хичээл сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах загварын төслийг боловсруулсан, 2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн туршихаар ажиллаж байна.	100%	100%

1.1.1	Ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициент, нэг ээлжээр хичээллэх сургуулийн боломжийг судалж, санал боловсруулна.	-	Ээлжийн коэффициентийн үнэлгээ, бүлэг дүүргэлт	-	Санал боловсруулсан байна.	Санал боловсруулсан байна.	1. Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициентыг 2023-2024 оны хичээлийн жилийн статистикийн мэдээлэлд үндэслэн (i) анги танхим ашиглалт, (ii) барилгын хүчин чадал ашиглалт гэсэн хоёр аргаар тооцлоо. Эдгээр үнэлгээний дүнг нэгтгэн нэгдсэн үнэлгээг тооцож гаргасан бөгөөд <1.1-ээс тохиолдолд “нэг ээлж”, 1.1-2.0 бол “хоёр ээлж”, 2.1-2.4 бол “судлах шаардлагатай”, 2.4-өөс дээш байгаа бол “яаралтай арга хэмжээ авах” гэсэн үзүүлэлтээр авч үзсэн. Тооцооллоор төрийн болон орон нутгийн өмчийн 695 сургуулийн 50.2 хувь буюу 349 (нийслэлд 35 сургууль) нь нэг ээлж, 46.3 хувь	100%	100%
-------	--	---	--	---	----------------------------	----------------------------	--	------	------

							буюу 322 (нийслэлд 114) нь хоёр ээлжээр тус тус хичээллэх боломжтой бол 3.5 хувь нь нормативаас өндөр байна. Өөрөөр хэлбэл, ээлжийн ачаалал 2.48-3.68 буюу “яаралтай” ангилалд 9 (нийслэлд 6), 2.12-2.59 буюу “судлах шаардлага” ангилалд 15 (нийслэл 8) сургууль, нийт 24 сургууль нормативаас өндөр гэсэн үг. Харин ээлжийн ачааллын үзүүлэлт 1.1-ээс бага боловч хоёр ээлжээр хичээллэж байгаа 147 (нийслэлд 18) сургууль байна. Холбогдох тооцооллыг Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн. 2. Нэг ээлжээр хичээллэх сургуулийн хичээл сургалт, үйл ажиллагааг зохион		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							байгуулах загварын төслийг боловсрууллаа. Уг төслийг боловсруулахдаа “Писа-2022”, “Боловсролын биет орчин, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулах зөвлөмж” тайлангуудад боловсролын үр дүнгийн чанар, тэгш байдлыг сайжруулахын тулд суралцагчдын сургалтын цаг ашиглалтыг оновчтой болгох, шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх ёстойг чухалчилсан хэрэгцээ, шаардлагад үндэслэн суралцагчдын сургууль дээр өнгөрөөх цагийг нэмэгдүүлж, тэдний хамтдаа суралцах, хөгжих, сайн сайхан байдлыг нь дэмжихэд чиглэсэн төлөвлөлтийн төслийг боловсруулсан		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							бөгөөд 2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн туршихаар ажиллаж байна. Хавсралт: 1 файл		
1.1.2	Ерөнхий боловсролын 3 ээлжээр хичээллэж байгаа болон 3 ээлжид шилжих эрсдэлтэй сургуулийн судалгаа гаргаж, 3 ээлжийг бууруулах чиглэлээр авах арга хэмжээний санал боловсруулна	-	Судалгаа, санал	-	Судалгаа хийсэн байна.	Санал боловсруулсан байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициентыг 2023-2024 оны хичээлийн жилийн статистикийн мэдээлэлд үндэслэн (i) анги танхим ашиглалт, (ii) барилгын хүчин чадал ашиглалт гэсэн хоёр аргаар тооцоолж, нэгдсэн үнэлгээг гаргасан бөгөөд <1.1-ээс тохиолдолд “нэг ээлж”, 1.1-2.0 бол “хоёр ээлж”, 2.1-2.4 бол “судлах шаардлагатай”, 2.4-өөс дээш байгаа бол “яаралтай арга хэмжээ авах” гэсэн үзүүлэлтээр авч үзсэн. Тооцооллоор төрийн болон орон нутгийн өмчийн 695 сургуулийн 50.2	100%	100%

							хувь буюу 349 (нийслэлд 35 сургууль) нь нэг ээлж, 46.3 хувь буюу 322 (нийслэлд 114) нь хоёр ээлжээр тус тус хичээллэх боломжтой бол 3.5 хувь нь нормативаас өндөр байна. Өөрөөр хэлбэл, ээлжийн ачаалал 2.48-3.68 буюу “яаралтай” ангилалд 9 (нийслэлд 6, Архангай-1, Ховд-1, Хөвсгөл-1), 2.12- 2.59 буюу “судлах шаардлагатай” ангилалд 15 (нийслэл 8, Баян- Өлгий-1, Говь- Алтай-1, Өвөрхангай-1, Өмнөговь-1, Хөвсгөл-1, Хэнтий- 1, Дархан-Уул 1) сургууль, нийт 24 сургууль нормативаас өндөр байна. "Судлах шаардлагатай" болон "яаралтай" ангилалд байгаа 24 сургуулийн талаар орон нутгийн БШУГ болон нийслэлийн		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							Боловсролын газартай хамтран ачааллыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Хавсралт: 1 файл		
1.1.3	Ерөнхий боловсролын сургуулийн менежментийг дэмжих үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангана.	1000.0	Зохион байгуулсан үйл ажиллагааны хамрах хүрээ, үр дүн	Зохион байгуулсан үйл ажиллагааны хамрах хүрээ, үр дүн	Сургуулийн менежментийн зөвлөмжийг 21 аймаг, 9 дүүргийн ЕБС-д түгээн дэлгэрүүлж, зөвлөн тусалсан байна.	Зөвлөн туслах, удирдах ажилтны чадавхжуулах үйл ажиллагааг ерөнхий боловсролын зорилтот 168 сургуульд зохион байгуулсан байна.	1. БШУ-ны сайдын “2023 оныг сургалтын байгууллагын менежментийг сайжруулах жил болгон зарлах тухай” А/01 дүгээр тушаал, “Удирдамж, багийн бүрэлдэхүүн батлах тухай” А/49 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх хүрээнд 2023 онд нийслэлийн 37, орон нутгийн 46 нийт 83 сургуульд сургалтын байгууллагын менежментэд арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт, зөвлөн туслах үйл ажиллагааг БШУЯ, харьяа байгууллагууд хамтран үе шаттай зохион байгуулсан. Эдгээр 83	100%	100 %

							сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд анализ хийвэл 76 сургууль буюу 91.5% нь ахисан үзүүлэлттэй гарсан. 2. Сургуулийн менежментийг сайжруулах арга зүйн зөвлөмжийг БСҮХ, менежментийн баг хамтран боловсруулсан бөгөөд 2024 онд энэхүү аргачлал зөвлөмжийг түгээн дэлгэрүүлэх, сургалтын байгууллагын менежментийн загвар сургуулиудыг бий болгох зорилгоор 21 аймгийн шинээр сонгогдсон 163 сургуульд Сургуулийн менежментийг сайжруулах сургалт зөвлөн туслах үйл ажиллагааг 1-6 дугаар сард дараах үе шаттайгаар зохион байгуулсан. Орон нутагт чиглүүлэн ажиллах 60 сургагч багшийг		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							бэлтгэж, 163 сургуулийн удирдах ажилтан, БШУГ-ын мэргэжилтнүүд, аймгийн зөвлөх болон ментор багш нар нийт 895 хүнийг хамруулан танхимын сургалт зохион байгуулсан. 3. Булган, Орхон, Хөвсгөл аймгийн нийт 71 ерөнхий боловсролын сургуулийн 264 удирдах ажилтанд сургуулийн менежментийг дэмжих арга зүйн сургалтыг зохион байгуулах, 3-5 дугаар сард 163 сургуулийн удирдах ажилтан, БШУГ-ын мэргэжилтнүүд 356 хүнд “Сургуульд суурилсан менежмент” онлайн сургалтыг зохион байгуулах зэрэгт БЕГ-ын СХХҮХГ-тай тасралтгүй хамтран ажиллаж байна. 4. ЕБС-д цахим, танхимын хосолсон сургалтыг зохион байгуулах хүний нөөцийг чадавхжуулах,		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							орчин бүрдүүлэхэд Боловсролын дэлхийн түншлэл ОУБ-ын санхүүжилтээр хэрэгжиж буй "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих" төсөл, АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах" төсөлтэй хамтран ажиллаж байна.		
1.1.4	Ерөнхий боловсролын салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын төсөл боловсруулж батлуулна.	-	Хичээлийн жилийн зорилго зорилт	-	Хичээлийн жилийн зорилго зорилтын хэрэгжилтэд шинжилгээ хийсэн байна	Шинэ хичээлийн жилийн зорилго, зорилтыг батлуулсан байна.	Боловсрол, шинжлэх ухааны сайдын баталсан "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарт 2023-2024 оны хичээлийн жилд дэвшүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилтийн тайланг аймаг, нийслэлийн боловсрол, шинжлэх ухааны газруудаас цуглуулж, шинжилгээ хийлээ.	90%	70%

							Хэрэгжилтийн тайланг Сэлэнгэ аймгаас бусад аймаг, нийслэлийн боловсрол, шинжлэх ухааны газрууд ирүүлсэн боловч тайлан хэт ерөнхий, тухайн зорилтыг хангахын тулд боловсролын газраас хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүн тодорхой бус, тухайн зорилтод хамааралгүй асуудал болон төсөл, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээг тайлагнах шинж агуулсан, үр дүн талаас нь нэгтгэн дүгнэх бус тоочин бичиж байгаа нийтлэг дутагдал ажиглагдаж байна. Хичээлийн жилд дэвшүүлсэн зорилтоос (i) Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийг суралцагч, эцэг эх, асран		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							хамгаалагчдад сурталчлан таниулах, (ii) аймаг, дүүрэг бүрд хоёр хүртэл ахлах сургуулийг 2024-2025 оны хичээлийн жилээс хичээллүүлэх бэлтгэл хангах, (iii) хүүхэд бүр гэртээ ойр байрлах сургуульд хамрагдах хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх, (iv) ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн онцлог, сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх, (v) дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах, сурах, хөгжих, төлөвших үйл явцыг дэмжихэд чиглэсэн тусгайлсан арга хэмжээ авах зорилтын хэрэгжилтийн талаарх мэдээлэл тайланд тодорхой бус байна. Боловсрол, шинжлэх ухааны		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							яам, Боловсролын ерөнхий газар, мэргэжлийн байгууллагууд хамтран сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын салбарын 2023-2024 оны хичээлийн жилийн дүгнэлт хурлыг цахим, танхим хосолсон хэлбэрээр 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр зохион байгууллаа.		
1.1.5	Ерөнхий боловсролын сургуулийн нэршлийг хуульд нийцүүлэн журамлах арга хэмжээний санал, шийдвэрийн төсөл боловсруулна.	-	БШУ-ны сайдын тушаал	-	ЕБС-ийн нэршлийн загварыг БШУ-ны сайдын тушаалаар батлуулсан байна.	-	Ерөнхий боловсролын сургуулийн нэршлийг Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн нэр томъёонд нийцүүлэх зорилгоор “Ерөнхий боловсролын сургуулийн нэршлийн загвар”-ыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/28 дугаар тушаалаар	100%	100%

							баталлаа. Энэ тушаалаар (i) сургуулийн нэрийг улсын хэмжээнд нэгдсэн загварын дагуу бичихээр зохицуулж, бичвэрийг тушаалын хавсралтаар баталсан, (ii) их, дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын сургуулиас бусад ерөнхий боловсролын сургуулийн нэрийн өмнө “харьяа/түшиц” гэсэн бичвэр хэрэглэхгүй байх, (iii) сургуулийн бүтэц, олон улсын хөтөлбөр, төрөлжсөн сургалтын нэр, төрийн одонгоор шагнагдсан болон гавьяат үйлстний нэрэмжит гэх зэрэг тодотголыг сургуулийн нэрэнд хэрэглэхгүй байх, (iv) шинээр байгуулах орон нутгийн өмчийн сургалтын байгууллагыг		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							оноосон нэрээр нэрлэх бодлого баримтлах, (v) ерөнхий боловсролын сургуулийг шагнасан төрийн дээд одон болон гавьяат үйлстний нэрэмжит болгосон шийдвэрийг тусгайлсан самбарт байршуулж байх зэрэг шаардлага, хязгаарлалт тавьсны гадна (vi) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт орсонтой холбогдуулан өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийг улсын бүртгэлд бүртгүүлэх, улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах ажлыг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулахаар зохицуулсан. Тушаалын хэрэгжилтийг хангах зөвлөмж боловсруулж,		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт Боловсрол, шинжлэх ухааны яамны газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 3/352 дугаар албан бичгээр хүргүүллээ. Мөн сургууль хуулийн этгээдийн нэр авах хүсэлт өгөх, түүнийг улсын бүртгэлийн байгууллагаас баталгаажуулахад аль нэг гадаад улсын нэрийг тухайлан заасан оноосон нэр олгохгүй байх шаардлага, хязгаарлалт тавих саналыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт БШУ-ны сайдын 2024 оны 1а/1808 албан бичгээр хүргүүлэв. Хавсралт: 2 файл		
1.1.6	Гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр ерөнхий	-	Төсөл хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилт	Төслийн удирдах хорооны баталсан төлөвлөгөө	Төсөл хөтөлбөрүүдийн төлөвлөгөө амжилттай	Төсөл хөтөлбөрүүдийн төлөвлөгөө амжилттай	1. БШУЯ, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Эдийн засгийн	100%	100%

	боловсролын салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангана.			(GPE, АХБ-ны ЭЗХБЧХД төсөл, ТХБ-ыг дэмжих төсөл)	хэрэгжсэн байна.	хэрэгжсэн байна.	хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэх төслийн 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсвийг Сангийн яамаар батлуулахад төслийн багтай хамтран ажиллав. Тус төслийн хүрээнд 2024 онд - Гурван ээлжээр хичээллэх эрсдэлтэй сургуулиудад дижитал танхим нийлүүлж, үр дүнтэй ашиглахад арга зүйн дэмжлэг үзүүлэх, - ЕБС-ийн гүйцэтгэл, үр дүнд суурилсан тогтолцоог бэхжүүлэх замаар сургуулийн менежментийг сайжруулах -ЕБС-ийн удирдах ажилтнууд болон Нийслэл, аймгуудын боловсролын газруудын мэргэжилтнүүд,НТ СТ-ийн мэргэжилтнүүдэд		
--	--	--	--	--	------------------	------------------	---	--	--

							зориулсан мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг онлайн систем ашиглан боловсруулж, сургалт зохион байгуулах, Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтэй уялдуулан сургалтын хөтөлбөрийн төсөл боловсруулах (суралцагчийн үнэлгээний туршилтыг зохион байгуулах, - Байгалийн ухааны лабораторийн ур чадвар, удирдлагын чиглэлээр байгалийн ухааны багш нарын 30%- ийг сургалтад хамруулах ажлуудад нийт 1.6 тэрбум төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн. 2. GPE- 2022 дугаар бүхий Боловсролын Дэлхийн Түншлэл (GPE) олон улсын байгууллагын буцалтгүй тусламжийн		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн хосолсон сургалт бүрэлдэхүүний зорилтот ЕБС-ийн багш нарт зориулсан сургалтыг 3 үе шаттай зохион байгуулах шийдвэр, холбогдох зардлын төсвийг боловсруулж, БШУ-ны сайдын 2024 оны 05 дугаар сарын 03 ны өдрийн А/213 дугаар тушаалаар батлуулан боловсролын газар, зорилтот сургуулиудыг мэдээллээр хангаж ажиллав. Тус төслөөс “Хосолсон сургалтын үеийн сургуулийн багш нарын заах арга зүйн чадавхыг бэхжүүлэх” сэдэвт сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгуулж, багш тус бүрт 1		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							буюу зорилтот 50 сургууль тус бүрт 3 зөөврийн компьютер олгоход тендерийн баримт бичигт заасан шаардлагад нийцүүлэн хүлээн авах ажлын хэсэгт ажиллаж , сургуулиудад үндсэн хөрөнгөд бүртгэх, ашиглах талаарх мэдээлэл, зөвлөмжийг ТНБД-ын албан тоотоор хүргүүлэв. Хавсралт: 9 файл		
1.1.7	Ерөнхий боловсролын сургалтын байгууллагад сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааг ЭЗХЯ, ГТСМТТ-тэй хамтран цахим хэлбэрт шилжүүлнэ.	-	Цахим систем, ашиглалт	-	Сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгуулах, сунгах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх цахим системийг ашиглаж эхэлсэн байна.	Сургалтын үйл ажиллагаа сунгах хүсэлтийг цахим системд суурилан тухай бүрд нь шийдвэрлэсэн байна.	Сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхтэй холбоотойгоор Гааль татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн мэргэжилтнүүдтэй 5 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг хийсэн. Гадаадын хөрөнгө оруулалттай ерөнхий боловсролын	100%	100%

							сургууль, олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль, их сургууль, дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын сургууль, Засгийн хоорондын хэлэлцээрээр байгуулагдах ерөнхий боловсролын сургууль, ерөнхий боловсролын сургуульд олгох зөвшөөрлийн ажлын даалгаврыг боловсруулан ГТСМТТ-д хүргүүлсэн. Зөвшөөрлийн нэгдсэн сан буюу www.license.mn-д БШУЯ-аас сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан 54 байгууллагыг бүртгэсэн. www.license.mn-д зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг тулгах, бичиг баримтыг шалгах, хянах,		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							баталгаажуулах эрхийн тохиргоо хийх, зөвшөөрөл тус бүрээр турших зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Тус системээр 2024 оны 3 дугаар сарын 15-29-ний өдрүүдэд тусгай болон энгийн зөвшөөрөл шинээр авах, сунгах хүсэлтүүдийг хүлээн авч БШУ-ны сайдын тушаалаар томилогдсон ажлын хэсэг бичиг баримтыг магадлан шалгаж, Зөвшөөрлийн тухай хуулинд заасны дагуу хуулийн хугацаанд нөхөн бүрдүүлэхээр хүсэлтийг буцаасан. Нөхөн бүрдүүлж ирүүлсэн бичиг баримтуудыг магадлан шалгаж ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн Боловсрол шинжлэх ухааны сайдын тушаалаар 3 сургуульд олон улсын хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							тусгай зөвшөөрөл, 1 сургуульд олон улсын хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх урьдчилсан зөвшөөрөл, их сургууль, дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрлийг 4 сургуульд шинээр олгосон. Олон улсын хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх 3 сургуулийн тусгай зөвшөөрөл, их сургууль, дээд сургуулийн харьяа 1 ахлах сургуулийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрлийг сунгаж Зөвшөөрлийн цахим мэдээллийн санд мэдээллийг тухай бүрд нь оруулсан.		
--	--	--	--	--	--	--	---	--	--

1.1.8	Ерөнхий боловсролын сургуулийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулахад удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж, бодлогын зөвлөмж боловсруулна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Гүйцэтгэлийн үнэлгээ, хамрагдсан байгууллага, багшийн тоо, тайлан, зөвлөмж	Багшийн гүйцэтгэлийн үнэлгээг 2022, 2023 онд зохион байгуулсан.	Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг 650 сургууль, 29000 багшийн хамруулан зохион байгуулсан байна.	Гүйцэтгэлийн үнэлгээний тайлан, зөвлөмж гарсан байна.	1. Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоолоор "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам"-ыг баталсан. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн болон байгууллагын үнэлгээг Боловсролын үнэлгээний төв, Боловсролын ерөнхий газар, аймаг, нийслэлийн боловсролын газар хамран 2024 оны 04 дүгээр сарын 29-нөөс 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулсан. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх,	90%	90%
-------	---	----------------------------	--	---	--	---	---	-----	-----

							урамшуулах журмын төслийг БНБТГ-аас боловсруулж, хэлэлцүүлэхэд оролцож санал өгч, хамтран ажиллсан.		
1.1.9	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын менежментийг сайжруулах бодлого, чиглэлийн хүрээнд захиргаа, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн ажилтнуудын төсөв, санхүү, хөрөнгийн менежментийн чадавхыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд СХОГ, БЕГ-тай хамтран ажиллана.	-	Сургалтын модуль, хамрагдсан хүний тоо	-	Одоогийн суурь нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, модуль сургалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж эхлүүлсэн байна.	Батлагдсан модуль сургалтад 500-аас доошгүй ажилтнуудыг хамруулсан байна.	1. БШУЯ, Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн хамтын гэрээний хүрээнд Боловсролын багц хуулийг ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтнуудад сурталчлан таниулах ажлыг 2024 оны 04 дүгээр сард зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан. Нийслэлийн Баянгол, Налайх дүүрэг, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгийн бүх ерөнхий боловсролын сургууль, Дархан-Уул аймгийн их дээд сургууль, мэргэжлийн	90%	90%

							боловсролын сургуулийн захирал, үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга нарт боловсролын багц хуулийг сурталчлан таниулах сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 08-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалтаар Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд сургуулийн менежмент, санхүүгийн хагас бие даасан байдал, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтууд, Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан "Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ, түүний бүрэлдэхүүн",		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							"Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр", "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам"-ыг тус тус танилцуулсан. 2. Сургуулийн менежментийг сайжруулах арга зүйн зөвлөмжийг БСҮХ, менежментийн баг хамтран боловсруулсан бөгөөд 2024 онд энэхүү аргачлал зөвлөмжийг түгээн дэлгэрүүлэх, сургалтын байгууллагын менежментийн загвар сургуулиудыг бий болгох зорилгоор 21 аймгийн шинээр сонгогдсон 163 сургуульд Сургуулийн менежментийг сайжруулах сургалт		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							зөвлөн туслах үйл ажиллагааг 1-6 дугаар сард дараах үе шаттайгаар зохион байгуулж, орон нутгийн 60 сургагч багшийг бэлтгэж, 163 сургуулийн удирдах ажилтан, БШУГ-ын мэргэжилтнүүд, аймгийн зөвлөх болон ментор багш нар нийт 895 хүнийг хамруулан танхимын сургалт зохион байгуулсан. 3. Булган, Орхон, Хөвсгөл аймгийн 71 ерөнхий боловсролын сургуулийн 264 удирдах ажилтанд сургуулийн менежментийг дэмжих арга зүйн сургалт зохион байгуулсан.		
1.2.	Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, үнэлгээ, хэрэгжилтийг боловсронгуй болгох	Батлагдсан төсвийн хүрээнд	-	-	-		Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал Монгол Улсын Засгийн газраар батлагдаж, сургуулийн өмнөх болон бага	100%	100 %

							боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн үйл ажиллагаа хэрэгжиж эхэллээ.		
1.2.1	Ерөнхий боловсролын сургуулиудад олон улсын PEARSON хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохицуулалтаар хангана.	Батлагдсан төсвийн хүрээнд	Сайдын тушаал, шийдвэр, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн анги, сургуулийн тоо	ЕБС-ийн 5-6 дугаар анги	2023-2024 оны хичээлийн жилд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, 2024-2025 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх санал боловсруулна.	2024-2025 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хамран хүрээг тогтоосон шийдвэр, тушаал албажсан байна.	БШУ-ны сайдын 2023 оны А/353 дугаар тушаалын дагуу 2023-2024 оны хичээлийн жилд цахим системд суурилсан англи хэлний Pearson English хөтөлбөр төрийн өмчийн ерөнхий боловсролын 665 сургуульд хэрэгжиж байгаа бөгөөд хөтөлбөрт 5-р ангийн 70089 суралцагч, 6-р ангийн 65585 суралцагч нийт 135675 суралцагч хамрагдаж байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 2222 англи хэлний багшид цахим болон танхимын хэлбэрээр арга зүйн чиглэлийн сургалт, үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна. Энэ хичээлийн жил	100%	100%

							давхардсан тоогоор 175 ментор багш, 2606 хэрэгжүүлэгч багшид 2 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулаад байна. Тухайлбал Пийрсон хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэгч багш нарыг чадавхжуулах сургалтыг 11 аймгийн 270 сургуулийн 312 удирдлага, 593 багш, нийслэлийн 7 дүүргийн 150 сургуулийн 225 удирдлага, 803 багшид тус тус зохион байгуулсан бөгөөд аймаг, дүүргийн БШУГ, Боловсролын хэлтсийн мэргэжилтнүүдэд цахим болон танхимын сургалтыг тогтмол зохион байгуулж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Цахим системд суурилсан англи хэлний Pearson English хөтөлбөр		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							хэрэгжсэнээр суралцагчдын хувьд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөрөөр суралцан хэлний мэдлэг чадвараа дээшлүүлэх, олон улсын үнэлгээ шалгалтуудад амжилт үзүүлэх боломжууд нээгдэж байгаа бол багш нарын хувьд дасгал, даалгаврын сан, үнэлгээний шинэлэг арга аргачлал бүхий системийг ашигласнаар ажлын ачаалал буурах, ажлын байрандаа хөгжих боломжууд нэмэгдэж байна. Ирэх хичээлийн жилд тус хөтөлбөрийг ЕБС-ийн 3-7 дугаар ангид хэрэгжүүлэхээр төлөвлөсөн .		
1.2.2	Байгалийн ухааны сургалтын чанарыг сайжруулахад	700.0	Хамрагдсан сургууль, багшийн тоо, боловсруулсан	-	Ерөнхий боловсролын 24 сургуулийн бага боловсролын	Ерөнхий боловсролын 24 сургуулийн бага боловсролын	Ерөнхий боловсролын 24 сургуулийн бага боловсролын багш нарт сургалт зохион	100%	100 %

	дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангаж, дэмжлэг үзүүлнэ.		жишиг төлөвлөлт		багш нарт сургалт зохион байгуулсан байна.	багш нарт сургалт зохион байгуулж, байгалийн ухааны хичээлийн арга зүйн жишиг төлөвлөлтүүд боловсруулан түгээсэн байна.	байгуулж, байгалийн ухааны хичээлийн арга зүйн жишиг төлөвлөлтүүд боловсруулан түгээх зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн "Сургалтын арга зүйд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зардал батлах тухай" А/488 дугаар тушаалыг боловсруулан батлуулсан. Тушаалын хэрэгжилтийг хангаж, 2024 оны эхний хагас жилд БЕГ-ын Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний хөгжлийн газартай сургагч багш нарын багийг бүрдүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллалаа. Үүний үр дүнд: 1. Байгалийн ухааны сургалтын чанарыг		
--	---	--	--------------------	--	---	---	---	--	--

							сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хичээлийн жишиг төлөвлөлт боловсруулан түгээх сургалт, судалгааны ажлыг зохион байгуулах "Багшлахуйн баясгалан сургалт судалгааны төв" НҮТББ-ын гүйцэтгэх захирал Э.Даваахүүгээр ахлуулсан багш нарын багт сургалт, үйл ажиллагааны удирдамж, сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлсэн. 2. Дээрх ажлын үр дүнд сургалтын баг нь нийслэл, орон нутгийн нийт 24 сургуулийн бага боловсролын 566 багш, 14 аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газар, 9 дүүргийн боловсролын хэлтсийн бага боловсролын мэргэжилтэн 12, нийт 578 хүнд Байгалийн ухааны		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							хичээлийн арга зүй, туршилтад хичээл төлөвлөх чиглэлээр сургалт, зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. 3. Сургалтын судалгааны үйл ажиллагааны үр дүнд IV ангийн “Соронзон”, “Гэрлийн шинж чанар”, V ангийн “Одод тэнгэр”, “Бодисын төлөвийн шилжилт”, “Эргэх ба үл эргэх өөрчлөлт” сэдэвт нийт 5 нэгж хичээлийн жишиг төлөвлөлтийг боловсруулан судалгаат хичээлүүдийг сургууль тус бүрийн түвшинд зохион байгуулсан. Цаашид жишиш нэгж хичээлийн төлөвлөлтийг хичээлийн судалгааны аргачлалд тулгуурлан сайжруулж, ерөнхий боловсролын сургуулиудад түгээн дэлгэрүүлэх ажлыг 2024 оны		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							сүүлийн хагас жилд зохион байгуулна . Хавсралт: 2 файл		
1.2.3	“Эдүтэн” цахим системийг ЕБС-д хэрэгжүүлэхэд удирдлага, зохицуулалтыг дэжмлэг үзүүлнэ	-	Батлагдсан төлөвлөгөө, хэрэгжилт	688 сургуулийн 3-4 дүгээр ангийн 142,189 суралцагч, БШУ-ны сайдын 2023 оны А/312, А/462 тушаалууд	2023-2024 оны хичээлийн жилийн хэрэгжилтийг үнэлж, 2024-2025 оны төлөвлөгөө, төсөв боловсруулсан байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн бүх сургуулийн 1-5 дугаар ангид хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна.	БШУ-ны сайдын А/312 дугаар тушаалын дагуу 2023-2024 оны хичээлийн жилд математикийн сургалтын Эдүтэн цахим систем төрийн өмчийн ерөнхий боловсролын 664 сургуульд хэрэгжиж байгаа бөгөөд цахим системд 3, 4 дүгээр ангийн 142,189 суралцагч долоо хоногт 1 цаг суралцаж байна. 2023-2024 оны хичээлийн жилд хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр Эдүтэн байгууллагын зөвлөх баг болон Эдүтэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний баг хамтран 7 хоног цахим сургалт зохион байгуулж, хэрэгжилтэд тулгарч байгаа	100%	100%

							асуудал, бэрхшээлүүдийг шийдвэрлэн ажиллаж байна. Эдүтэн байгууллагын зөвлөх баг болон Эдүтэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний баг хамтран цахим системийг нэвтрүүлэх төлөвлөгөөний дагуу 2023-2024 оны хичээлийн жилд давхардсан тоогоор нийт 5014 багш, сургалтын менежерийг шатаалсан сургалтуудад хамруулж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Тухайлбал 65 багшийг үндэсний сургагч багшаар, 1000 багшийг дэмжигч багшаар бэлтгэж, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 3249 багш, 700 сургалтын менежерүүдийг шатаалсан сургалтуудад хамруулсан. Эдүтэн		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							цахим системийг нэвтрүүлснээр 3,4 дүгээр ангийн суралцагчид нийт 620 мянган хичээл судалж, долоо хоногт дунджаар 20-30 сая бодлого бодож байгаа бөгөөд энэ хичээлийн жил (2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар) 3,4 дүгээр ангийн суралцагчид нийт 500 сая гаруй бодлого амжилттай бодсон үзүүлэлттэй байна. 2024-2025 оны хичээлийн жилд төрийн болон орон нутгийн ЕБС-ийн 1-5 дугаар ангид EDUTEN хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 5000.0 сая /5 тэрбум/ төгрөгийн санхүүжилт шаардагдах урьдчилсан тооцоо гарсан бөгөөд 2025 оны төсвийг төсөлд тусгаад байна.		
1.2.4	PISA -2022 олон улсын судалгааны	-	Сэдэвчилсэн тайлан,	Чанарын судалгааны тайлан 2022	Сэдэвчилсэн тайлан гарсан байна.	Туршилт судалгаан зохион	Дэлхийн банкны санхүүжилтээр PISA 2022 сурлагын	100%	100 %

	сэдэвчилсэн тайлан боловсруулах, туршилт судалгааг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангаж, мэргэжлийн байгууллагуудт ай хамтран ажиллана.		туршилт судалгаа			байгуулсан байна.	амжилтын шалгалтын үр дүнд сэдэвчилсэн тайланг 2024 оны 05 дугаар сард танилцуулсан. Шалгалтын үр дүнг бүсчилсэн болон нас, хүйс, нөлөөлж буй хүчин зүйлсээр нь гаргасан. Хавсралт: 1 файл		
1.2.5	Нэг ээлжээр хичээллэх сургуулийн сургалтын зохион байгуулалт, сургалтын төлөвлөгөөний төсөл боловсруулж турших	-	Сургалтын төлөвлөгөөний хувилбар, төсөл	-	Нэг ээлжээр хичээллэх сургуулийн сургалтын төлөвлөгөөний төсөл боловсруулсан байна.	Сургалтын төлөвлөгөөний төслийг туршсан байна	Нэг ээлжээр хичээллэх сургуулийн хичээл сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах загварын төслийг боловсрууллаа. Уг төслийг боловсруулахдаа “Писа-2023”, “Боловсролын биет орчин, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулах зөвлөмж” тайлангуудтай танилцсан бөгөөд боловсролын үр дүнгийн чанар, тэгш байдлыг сайжруулахын тулд	70%	70%

							суралцагчдын сургалтын цаг ашиглалтыг оновчтой болгох, шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх ёстойг чухалчилсан байна. Энэхүү хэрэгцээ, шаардлагад үндэслэн суралцагчдын сургууль дээр өнгөрөөх цагийг нэмэгдүүлж, тэдний хамтдаа суралцах, хөгжих, сайн сайхан байдлыг нь дэмжихэд чиглэсэн төлөвлөлтийн төслийг боловсруулсан бөгөөд 2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн туршихаар ажиллаж байна. Хавсралт: 1 файл		
1.2.6	Улсын төрөлжсөн олимпиад, олон улсын олимпиадыг зохион байгуулах, олон улсын олимпиадад	Батлагдсан төсвийн хүрээнд	Хамрагдсан багш, суралцагчийн тоо	-	Улсын төрөлжсөн олимпиад: 12 судлагдахуунаар зохион байгуулсан байна.	Олон улсын олимпиадад 6 төрлөөр багууд оролцсон байна. Амжилттай оролцогчдыг шагнаж,	1. Боловсролын ерөнхий хуулийн 27.15-д заасны дагуу Улсын олимпиад зохион байгуулах журмын төслийг боловсруулах, сайжруулахад	100%	100%

	амжилттай оролцсон суралцагч, багш, олимпиадын хороодыг шагнаж, урамшуулах үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангана.					урамшуулсан байна.	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний хөгжлийн газрын мэргэжилтнүүд, Улсын олимпиад зохион байгуулах дэд хороодтой хамтран ажилласнаар тус журам нь Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/420 дугаар тушаалаар батлагдсан. 2. Дээрх журмын дагуу 2023-2024 оны хичээлийн жилд БЕГ-ын даргын А/56, А/100 дугаар тушаалаар улсын олимпиадыг зохион байгуулах төсвийг /536,782,600 төг/ батлан 12 судлагдахууны олимпиадыг Улсын олимпиадын хороод 3-5 дугаар сард зохион байгууллаа. Олимпиадад Улсын хэмжээнд 9 ба 12-р ангийн 2000 суралцагч, 200		
--	--	--	--	--	--	--------------------	--	--	--

							гаруй багш оролцож, судлагдахууны онцлогоос хамаарч нийт оролцогчдын 11% нь буюу 218 суралцагч медаль хүртсэн нь өмнөх жилүүдээс оролцогч болон шагналт байрын тоо нэмэгдсэн, Монгол хэл-Уранзохиол, Монгол бичиг хичээлийн олимпиадыг тус тусад нь зохион байгуулсан онцлогтой байна. 3. Хөдөө орон нутагт 3 судлагдахууны олимпиад зохион байгуулагдсан. Улс, бүсийн олимпиадыг орон нутагт зохион байгуулах нь Төр, Төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, орон нутаг, боловсролын байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, идэвх оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой байна. 4.		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							Олимпиадын дэд хороодын баталсан удирдамжийн дагуу олон улсын олимпиадад оролцох суралцагчдыг сонгон шалгаруулж, БЕГ-ын даргын 2024 оны А/59 дүгээр тушаалаар зардал /382,114,242 төг/, багийн бүрэлдэхүүнийг баталсан. 2023-2024 оны хичээлийн жилд Монгол улсаас олон улсын олимпиадад Математик, Физик, Хими, Биологи, Газарзүй, Мэдээлэл зүй гэсэн 6 төрлөөр 27 сурагч, 17 багш оролцоно. Олон улсын математикийн олимпиад Англи улсад, Физикийн олимпиад Иран улсад, Химийн олимпиад Саудын Арабын хант улсад, Биологийн олимпиад Казакстан улсад тус тус 2024 оны 7 дугаар сард, газарзүйн		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							олимпиад Ирланд улсад 8 дугаар сард, Мэдээлэл зүйн олимпиад Египет улсад тус тус зохион байгуулагдана.		
1.2.7	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын унших чадварыг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ	Батлагдсан төсвийн хүрээнд	Төлөвлөгөө, хамарсан хүрээ, хэрэгжилт	2023 онд ЕБ-ын 5 сургуульд бага ангийн сурагчдын унших чадварыг дэмжих туршилт зохион байгуулсан.	Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан байна.	Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан байна.	1. ЕБС-ийн суралцагчийг багаас нь эх хэл дээрээ уншиж, ойлгох чадварыг хөгжүүлэх, сонирхолтой арга зүйг бүтээх, эх хэл ба сэтгэлгээг хослуулан хөгжүүлэх боломжийг судлан турших зорилготой “Нулимсгүй уншиж, бичиж сурцгаая” аргачлал, сурах бичиг, хэрэглэгдэхүүнийг онлайн хичээлийн хамтаар туршин хэрэгжүүлж байна. Туршилтыг БСҮХ зохион байгуулж, зүүн, төвийн, баруун бүсийн аймгуудаас тус бүр 1 аймгийг сонгон аймаг бүрээс 6 сургууль, 2-4 сургууль, орон нутгийн нийт 18,	100%	100%

						нийслэлийн 12 сургуулийг сонгон хэрэгжүүлж байна. Тус ажлын удирдамж боловсруулах, туршилт, хэрэглэгдэхүүний зардлыг шийдвэрлэх талаар БШУ-ны сайдын тушаал шийдвэрийн төсөл боловсруулан албажуулах зэргээр үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллалаа. 2. БЕГ нь 2023 онд ЕБС-ийн 5 сургуульд ЕБС-ийн менежмент-Номын сангийн үйл ажиллагаа сэдэвт төслийг хэрэгжүүлсэн. Энэхүү үйл ажиллагааг үргэлжүүлэн 2023-2024 оны хичээлийн жилд Уншигч хөтөлбөрийг ЕБ-ын 20 сургуульд хэрэгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулахад БЕГ-ын СХХҮХГ-тай нягт хамтран		
--	--	--	--	--	--	---	--	--

							ажиллаж байна. Тус ажлын хүрээнд Уншигч ТББ-тай хамтран "Бичиг үсэгт тайлагдсан байдлыг эрхэмлэх соёлыг оролцоог нэмэгдүүлэх замаар сургуулиудад төлөвшүүлэх нь" зөвлөмжийн төслийг боловсруулсан. /хавсаргав/ Хавсралт: 5 файл		
1.2.8	Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, агуулгад авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдвийг тусгах чиглэлээр шинжилгээ хийж, санал боловсруулах	-	Агуулга, сэдвийг тусгах санал	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалы н төсөл	-	Сургалтын хөтөлбөрт авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх чиглэлээр тусгах агуулгын санал тодорхой болсон байна.	УИХ-ын 2023 оны 59 дугаар тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023-2030 он/-ийн 9.4.1-д заасан Хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэх ёс зүй, ёс суртахууны зөв төлөвшил олгоход чиглэсэн сургалт, нөлөөллийн хөтөлбөрийг насны ангилал, орчин үеийн чиг хандлагад нийцсэн байдлаар судалгаанд	100%	100 %

							тулгуурлан боловсруулах зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд “Ёс суртахууны хариуцлага” сургалтыг дэмжих хөтөлбөрийг ерөнхий боловсролын сургуульд турших, хэрэгжүүлэх үйл ажиллагааг БСҮХ, АТГ-тай хамтран зохион байгуулж байна. Энэхүү ажлын хүрээнд ЕБС-д хэрэгжүүлэх “Ёс суртахууны хариуцлага чадамж” сургалтыг дэмжих хөтөлбөр(туршилт)- ийг боловсруулан туршихад Боловсролын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, их дээд болон ерөнхий боловсролын сургуулийн төлөөллөөс бүрдсэн багтай		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							хамтран ажиллаж байна. Хамтарсан баг нь “Ёс суртахууны хариуцлага чадамж”-ийг сургалтыг дэмжих хөтөлбөр боловсруулан, туршин хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш нарт хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад нэмэлт ачаалал үүсгэхгүй байх зорилгоор чадамжийн хүрээ бүрээр “ЁС ЗҮЙ, ЁС СУРТАХУУН, ШУДАРГА ЁС” агуулгын хүрээгээр хичээлд хэрэглэх иж бүрэн сургалтын хэрэглэгдэхүүнийг систем, шатлалтайгаар боловсруулан туршиж, ерөнхий боловсролын 16 сургуулийн 10 дугаар ангийн нэг бүлгийг сонгон “Ёс суртахууны		
--	--	--	--	--	--	--	--	--	--

						хариуцлага чадамж” сургалтыг дэмжих хөтөлбөрийг 6 цагийн туршилт хичээлээр хэрэгжүүллээ. Дээрх хөтөлбөрийг 2023-2024 оны хичээлийн жилийн III улиралд 2 удаа, IV улиралд 4 удаа нийгэм судлал, иргэний ёс зүйн боловсрол хичээлийг агуулгыг дэмжих зорилгын хүрээнд түүх, нийгмийн ухааны багш нар хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулав. “Ёс суртахууны хариуцлага чадамж” сургалтыг дэмжих хөтөлбөрийн туршилтад нийслэлийн 8, орон нутгийн 8 сургуулийн 468 сурагчийг хамруулсан.		
1.3.	Ерөнхий боловсролын сургалтын сургалтын	Батлагдсан төсвийн хүрээнд	-	-	-	2023-2024 оны хичээлийн жилд сурах бичгийн хүрэлцээ,	90%	90%

	орчин, хэрэглэгдэхүүнийг боловсронгуй болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх						хангамжийг бүрэн шийдвэрлэсэн. 2024-2025 оны хичээлийн жилийн хүрээнд 1,8 сая ширхэг сурах бичгийг хэвлүүлэн түгээх бэлтгэл ажлыг хангаж байна. Мөн бага ангийн 33 төрлийн сурах бичгийн агуулга, дасгал даалгаврыг интерактив хэлбэрт хөрвүүлэх, 13000 орчим интерактив дасгал, даалгаврын сан бүрдүүлэх ажил хийгдсэн.		
1.3.1	Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн хүртээмжийг сайжруулахад удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.	Батлагдсан төсвийн хүрээнд	Сурах бичгийн хангалтын хувь	70	Сурах бичиг ханган нийлүүлэх төлөвлөгөө, зардал батлагдсан байна.	Сурах бичгийн хангалт бага ангид 100 хувь, дунд, ахлах ангид 85,0 хувьд хүрсэн байна.	Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/37 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуульд 2024- 2025 оны хичээлийн жилийн I-V ангид ашиглах 25 нэрийн, VI-XI ангийн 94 нэрийн сурах бичиг хэвлэх, нийлүүлэх шаардагдах 5.4 тэрбум төгрөгийн зардал батлагдсан. Гэрэгэ системийн	100%	100 %

							тусламжтайгаар 2024-2025 оны хичээлийн жилд ашиглах сурах бичгийн захиалгыг 2024 оны 02 дугаар сарын 01-ээс 3 дугаар сарын 14- ний өдрийг дуустал авснаар 6-р ангид 27314 багц, 7-р ангид 22088 багц, 8- р ангид 23247 багц, 9-р ангид 20103 багц, 10-р ангид 18669 багц, 11-р ангид 18692 багц, 12-р ангид 11655 багц тус тус хэвлүүлэхээр санал ирүүлсэн бол 1-р ангид 239747 ш, 2-р ангид 190331 ш, 3-р ангид 72582 ш, 4-р ангид 246320 ш, 5-р ангид 199130 ш сурах бичгийн захиалга ирсэн.ЕБС-ийн I-XII ангийн сурагчдыг 2024-2025 оны хичээлийн жилд сурах бичгээр хангах, сурах бичиг хэвлэх, тээвэрлэн түгээхтэй холбоотой зохион байгуулалтын ажил төлөвлөгөөний		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							дагуу хийж байна. Боловсролын ерөнхий газар 2024 оны эхний хагас жилийн байдлаар I-XI ангийн 115 нэрийн 1,8 сая ширхэг сурах бичгийг нээлттэй тендер шалгаруулалтын дагуу хэвлэлийн 5 компанитай гэрээ хийж, 5 дугаар сарын 20-ны өдөр бүрэн хүлээж авсан. "Сурах бичиг тээвэрлэн хүргэх" нээлттэй тендер шалгаруулалт амжилттай болж, 5 дугаар сарын 28-ны өдөр гэрээ байгуулан, ерөнхий боловсролын 791 сургуульд тээвэрлэн хүргэх ажлыг "Монгол шуудан" ХК 990,0 сая төгрөгийн өртгөөр хийхээр гэрээ байгуулан ажиллаж байна. 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдөр бүрэн хүлээлгэж өгч дуусна. Ингэснээр 2024-2025 оны хичээлийн жилийн		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							эхэнд буюу 9 дүгээр сарын 01-ний өдөр суралцагчид шинээр хэвлэсэн сурах бичгээ хүлээн авах боломж бүрдэж байна.		
1.3.2	Бага ангийн цахим сурах бичиг ашиглах зөвлөмж боловсруулж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ.	-	Зөвлөмж	-	Зөвлөмжийн төсөл боловсруулсан байна.	Зөвлөмжийг боловсруулан түгээсэн байна.	Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн хэвлэмэл сурах бичгийг дижитал хэлбэрт хөрвүүлэх, сургалтад цахим сурах бичгийн систем турших ажлын хүрээнд бага ангийн 33 төрлийн сурах бичгийн агуулга, дасгал даалгаврыг интерактив хэлбэрт хөрвүүлэх, 13000 орчим интерактив дасгал, даалгаврын сан бүрдүүлэх, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн түшиц ерөнхий боловсролын сургууль дээр турших ажил хийгдэж байна. Бага ангид цахим сурах бичиг	70%	70%

							ашиглах зөвлөмжийг видео болон цаасан хэлбэрээр боловсруулах ажил хийгдэж байна.		
1.3.4	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын орчны стандартын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийхэд Салбарын хяналтын газартай хамтран ажиллана.	-	Хяналт үнэлгээний тайлан	-	Төлөвлөгөө гарсан байна.	Стандартын хэрэгжилтэд хяналт хийж, тайлан боловсруулсан байна.	2024 оны 3 дугаар сарын 22-ны өдөр ЕББУЗГ болон БЧҮХ, БЕГ-ын мэргэжилтнүүдийн хамт Сонгинохайрхан дүүргийн 121 дүгээр сургууль дээр очиж ажилласан. "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх журам"-ын төслийг тус сургууль дээр туршиж тохироц шалгах ажлын хүрээнд MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал, Ерөнхий шаардлагын дагуу үнэлгээ хийсэн. Ерөнхий боловсролын	100%	100 %

							сургуулийн ерөнхий боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсанд "Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS6782:2019 стандарт"-ын хүрээнд сургалтын орчны чиглэлээр нэмж тусгах зүйл, заалтын талаарх саналыг боловсруулсан Салбарын хяналтын газарт хүргүүлээ.		
1.4.	Ерөнхий боловсролын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах	-	-	-	-		Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 192 дугаар тушаалаар багшийн гурван тулгуурт бодлого батлагдсан. Багшийн мэргэжлийн хөгжлийн үндэсний төвийн нээлтийн үйл ажиллагаа болсон.	100%	100%
1.4.1	"Чадварлаг багш" арга хэмжээний	-	Стандартын төсөл	-	Ур чадварын стандартын төсөл	Стандартын төслийг	Багшийн 3 тулгуурт бодлогыг баримт бичиг	30%	30%

	хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн багшийн ур чадварын стандартын төсөл боловсруулна				боловсруулсан байна.	хэлэлцүүлсэн байна.	батлагдсантай уялдуулан багшийн ур чадварын стандартын төслийг боловсруулах ажил эхлэж байна.		
1.4.2	Багшийн эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагааг бодлого, зохицуулалтаар хангана.	-	Төв үйл ажиллагааны чиглэл, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн багш, ажилтны тоо	2023 онд БЭМД төв байгуулагдса н.	Төвийн үйл ажиллагааг чиглэл, бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан байна	Төвийн үйл ажиллагааг чиглэл, бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан байна	Монгол Японы эмнэлгийг түшиглэн багшийн эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагааг 2023 оны 10 дугаар сараас эхлүүлээд байна. Энэ төв нь эмнэлгийн туслаж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэсэн үндсэн хоёр чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана. Багш нар өрхийн болон аймаг дүүргийн эрүүл мэндийн төвд үзүүлнэ. Энэ үзлэгийн мөрөөр гуравдугаар шатлалын эмнэлэгт хандах шаардлага үүсвэл сургууль, цэцэрлэгийнхээ эмчээр дамжуулан багшийн эрүүл	90%	90%

							мэндийг дэмжих төвд хандах юм. Тус төв багшид шаардлагатай зөвлөгөө, мэдээллийг өгч, үзлэгийн болон хэвтэн эмчлүүлэх цаг захиалж өгнө. Зарим тохиолдолд гуравдугаар шатлалын бусад эрүүл мэндийн байгууллагад мөн холбон зуучлах юм. Мөн энэ төвийн эмч, мэргэжилтнүүд боловсролын байгууллагын эмч нарт цахим болон танхимын сургалт зохион байгуулна. Энэ хичээлийн жилд эмч нарыг хамруулан артерийн даралт ихсэлт, томуу томуу төст өвчний дэгдэлт, толгойн өвдөлт гэсэн цуврал сургалтуудыг зохион байгуулан ажиллаж байна. Хавсралт: 1 файл		
--	--	--	--	--	--	--	---	--	--

1.4.3	Багшийн хөгжлийн үндэсний болон бүсийн төвийн үйл ажиллагааг эхлүүлэхэд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.	-	МУХТЖҮЧ 2.1.7, ЗГҮАХХТ 1.1.15, 2.3.8,	-	Үндэсний төв байгуулагдаж, хүний нөөц бүрдсэн байна.	Төвийн үйл ажиллагааг эхлүүлсэн байна	Багшийн мэргэжлийн хөгжлийн үндэсний төвийг 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр МУБИС дээр нээсэн. Тус төвөөр багшийн гэрчилгээтэй болон дипломтой сургалтууд зохион байгуулагдана. Хавсралт: 2 файл	100%	100%
1.5.	Сургуулийн орчин дахь хүүхдийн хөгжил, хамгаалал, орчны аюулгүй байдлыг хангах, багш, ажилтан, суралцагч, олон нийт, эцэг, эх асран хамгаалагчдын оролцоог дэмжих	Батлагдсан төсвийн хүрээнд	-	-	-	-	Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан хувьсах зардлын бүрэлдэхүүнд ХҮҮХЭД ХАМГААЛАЛ-ын зардал батлагдсан. Equity Lab ТББ-тай хамтран “After school” цахим систем /аппликейшн/-ийг нэвтрүүлж дэлхийн иргэний боловсрол, мэргэжил сонголттой холбогдох 8 чиглэлийн 30 төрлийн хичээлээс сонгон сургалт, үйл ажиллагаанд	100%	100%

							хамрагдах боломжийг бүрдүүлж, 2,300 нийгмийн ажилтан, 49,337 суралцагчийг хамруулж, хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүллээ.		
1.5.1	Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний зардал төлөвлөх, хуваарилах заавар боловсруулна.	-	Зааврын төсөл	-	Зардал төлөвлөх, хуваарилах заавар боловсруулж, батлуулсан байна.	-	УИХ-ын 2023 оны нэгдсэн чуулганаар батлагдсан Боловсролын ерөнхий хуулиар “Боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт”-ийн зардлын бүрэлдэхүүнд сургуулийн орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын зардлыг багтаасан. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын зардлыг төлөвлөх, зарцуулах заавар”- ын төслийг	100%	100 %

							боловсруулж, сургуулийн нийгмийн ажилтнуудын төлөөлөл, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн болон Боловсролын ерөнхий газрын холбогдох газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийг оролцуулан 3 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, гарсан санал, зөвлөмжийг тусган эцэслэж, Санхүүгийн хэлтэст хүлээлгэн өгсөн. Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолд өөрчлөлт орсонтой холбоотой Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар батлуулах ажил хүлээгдэж байгаа талаар Санхүүгийн хэлтсээс мэдээлэл өгсөн. Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							зардлыг сургуулийн хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагаа, эрсдэлийн үнэлгээнд суурилан төлөвлөх бөгөөд хүүхэд хамгааллын зардлын төсвийн 50-аас доошгүй хувийг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд, 30 хүртэлх хувийг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд, 20 хүртэлх хувийг шуурхай тусламжийн үйлчилгээнд зарцуулахаар тусгалаа. Энэхүү заавар батлагдсанаар сургууль, дотуур байрны орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн болон өртөх эрсдэлтэй суралцагчийг илрүүлэх, эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх, тэдний аюулгүй байдлыг хангах, хүүхэд хамгааллын		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							холбогдох байгууллагад мэдээлэх, хүчирхийллийн хохирогч, холбогдогч суралцагчийг нөхөн сэргээх, чадавхжуулах, дахин хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэхэд чиглэсэн үйлчилгээ, үйл ажиллагааг чанартай, хүртээмжтэй хүргэх боломж бүрдсэн. Хавсралт: 1 файл		
1.5.2	Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаанд хамрагдах хүртээмжийг нэмэгдүүлэх цахим систем /after school/-ийг нэвтрүүлнэ.	-	Цахим систем, хэрэглэгчийн тоо	2700 суралцагч хамрагдсан.	-	Цахим системээр дамжуулан хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10 дахь хэсэгт “Суралцагчийн суралцах үйл ажиллагаа, хөгжил төлөвшлийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа нь ерөнхий боловсролын	100%	100%

							сургуулийн үйл ажиллагааны салшгүй хэсэг байна.” гэж заасан. 2023-2024 оны хичээлийн жилд төрийн өмчийн ерөнхий боловсролын 695 сургуульд 701,065 суралцагч суралцаж байгаагаас сургууль дээрх хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа, секц, дугуйланд давхардсан тоогоор 420,639 суралцагч буюу нийт суралцагчдын 60% нь хамрагдаж байна. Орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцагчийг хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаанд тэгш, хүртээмжтэй оролцуулах зорилгоор Equity Lab ТББ-тай хамтран “After school” цахим систем /аппликейшн/-ийг нэвтрүүлж дэлхийн		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							иргэний боловсрол, мэргэжил сонголттой холбогдох чиглэлийн 8 30 төрлийн хичээлээс сонгон сургалт, үйл ажиллагаанд хамрагдах боломжийг бүрдүүллээ. Энэхүү “After school” цахим систем нь ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан хүүхдийн өсөлт хөгжлийн цогц платформ бөгөөд хичээлээс гадуурх цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, өсвөр насанд зориулсан менторшип, коучинг, сэтгэлзүйн зөвлөгөөг ганцаарчилж авах, нийгэм, хүрээлэн буй орчныхоо сайн сайхны төлөө хийж буй сайн дурын ажил, санаачлагаараа хийсэн эерэг үйлдлүүдээ бүртгэлжүүлж,		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							урамшуулал бэлэг авах боломжтойгоороо ач холбогдолтой юм. Цахим системд 2,300 нийгмийн ажилтан, 49,337 суралцагчийг хамруулж, хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүллээ. Хавсралт: 1 файл		
1.5.3	“Эрүүл шүд” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтэд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.	-	Төлөвлөгөө, батлагдсан тушаал	Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоол	"Эрүүл шүд" арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан байна.	Хэрэгжилтэд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлсэн байна.	Эрүүл мэндийн сайд, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024 оны А/27/А/25 дугаар хамтарсан тушаалаар “Эрүүл шүд” арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоол, “Эрүүл шүд” төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр ерөнхий боловсролын 183 сургууль улсын болон орон нутгийн	100%	100 %

							төсвийн хөрөнгө, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын хөрөнгө оруулалт, эцэг эхчүүдийн дэмжлэг (53.3 сая төгрөг)-ээр шүд угаах цэг байгуулсан байна. Мөн 186 сургууль шүд угаах цагийн зохицуулалт хийж бага ангийн суралцагчид их завсарлагааны үеэр шүд угаах боломжтой болсон. Ерөнхий боловсролын сургуулийн 13.2 хувь буюу 123 сургууль улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр, төрийн бус байгууллагын санхүүжилтээр амны хөндийн эрүүл ахуйн үзүүлэн, макет зэрэг хэрэглэгдэхүүнээр хангагдсан. Шүд, амны хөндийн эрүүл мэндийн сургалтад 21 аймаг, 9 дүүргийн 331,459		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							суралцагч хамрагдсан бөгөөд 315,735 суралцагч шүд, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсанаас 54,880 суралцагчийн шүдийг эрүүлжүүлж, 20,429 суралцагч сургуулийн орчинд шүдээ угааж хэвшсэн байна. Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих сургалт, үйл ажиллагааг 527 сургууль зохион байгуулж 136558 эцэг эх, асран хамгаалагчдыг хамруулсан. Хавсралт: 2 файл		
1.5.4	“Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйлийн судалгаа-2023” судалгааны үр дүнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний	-	Зөвлөмж	Судалгааны тайлан	Зөвлөмж боловсруулан Боловсрол, сургалтын байгууллагуудад хүргүүлсэн байна.	-	Хүүхдийг аливаа болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний аюулгүй байдлыг хангахад тэргүүлэх чиг үүрэг бүхий Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол,	100%	100%

	зөвлөмж боловсруулна.						шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам хамтран “Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйлийн судалгаа” үндэсний түүвэр судалгааг ерөнхий боловсролын сургуульд суурилан 13-17 насны суралцагчдын оролцоотой зохион байгуулж, үр дүнг үндэсний түвшинд тархаасан. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 27,2 хувь буюу 4 суралцагч тутмын 1 нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд сургуулийн орчинд /сургуулийн коридор, анги, хичээлийн танхим, ариун цэврийн өрөө, биеийн тамирын заал гэх мэт хүүхэд олноор цуглардаг газар/ аюулгүй байдал алдагдсан, 38,8 хувь буюу 5 суралцагч тутмын 2		
--	--------------------------	--	--	--	--	--	--	--	--

							нь сургуульд ирж, буцахдаа ямар нэг тээврийн хэрэгслээр зорчдог, эмэгтэй суралцагчдын 64.0 хувь нь сургуульдаа ирж, буцахдаа гэрлэн дохионы ажиллагаагүй байдал, халтиргаатай зам, гэрэлтүүлэггүй гудамж, архи уудаг хүмүүс цуглардаг газар, нохой, автомашины хөдөлгөөнөөс эмээх зэрэг саад бэрхшээлтэй тулгардаг, 3 суралцагч тутмын 1 нь сургууль дээрээ үе тэнгийнхний дээрэлхэлтэд өртөж байсан гэсэн үр дүн гарсан. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хүчирхийлэл, хорт зуршил, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, орчин нөхцөлийг сайжруулах,		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							нийгмийн сөрөг үзэгдлээс хамгаалах зөвлөмжийг боловсруулж, БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 2/1017 тоот албан бичгээр БШУГ-т хүргүүлж, хэрэгжилтийг хангах, хяналт тавих чиглэлийг өгсөн. Хавсралт: 1 файл		
1.5.6	Иргэний эрүүл мэндийн боловсролын дээшлүүлэх арга хэмжээ, төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангана.	-	Арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилт	ЗГ-ын 2023 оны 321 дүгээр тогтоол	Арга хэмжээ, төлөвлөгөө батлагдсан байна.	Төлөвлөгөөнд 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан үйл ажиллагааны хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж, тайлагнасан байна.	Засгийн газрын 2023 оны "Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай" 321 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Эрүүл мэндийн сайд, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн	100%	100%

							хамгааллын сайдын хамтарсан тушаалын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг боловсруулан БШУ-ны сайдын албан бичгээр ЭМЯ-нд хүргүүлсэн. Тус арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт БШУЯ-аас ЕББУЗГ, БНБТГ-ын шинжээч нар ажиллаж, яамдаас ирсэн саналыг хэлэлцэн төлөвлөгөөний төслийг сайжруулж, арга хэмжээ, төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайд, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/75/09/73/34 дүгээр хамтарсан		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							тушаалаар батлуулсан. Хавсралт: 1 файл		
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
3.1.	Ерөнхий боловсролын салбарын нийтлэг харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг бодлогын удирдлага, зохицуулалтаар хангах	-	-	-	-		2024 оны эхний хагас жилийн байдлаар 5 журмыг батлуулсан байна. Бусад холбогдох тогтоол, дүрэм, журамд саналаа тусган ажилласан байна.	90%	90%
3.1.1	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал зүйл)-ийг УИХ-ын хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт дэмжлэг үзүүлнэ.	-	Хуулийн төсөл, баталсан шийдвэр	2016 онд батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хууль	УИХ-ын хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт дэмжлэг үзүүлсэн байна.	-	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал зүйл)-ийг УИХ-ын хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж, хуулийн төслийн 23 дугаар зүйл буюу “Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал” зүйлд	100%	100%

							санал өгч, сайжруулан хамтарч ажиллалаа. Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал зүйлд: сургалтын байгууллагын орчин, дотуур байранд хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ; үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ; эцэг, эх, боловсролын байгууллагын талуудын үүрэг оролцоо; боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний үүрэг, оролцоо зэргийг тодорхойлж, нарийвчилсан зохицуулалтуудыг орууллаа. УИХ-ын нэгдсэн чуулганаар		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлж тайлбар мэдээлэл болон судалгааны үр дүнг нэгтгэн бэлтгэж, оролцлоо. Хавсралт: 1 файл		
3.1.2	Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм боловсруулна.	-	Эрх зүйн актын төсөл, Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал	-	Сургуулийн үлгэрчилсэн дүрэм боловсруулсан байна.	-	Боловсролын ерөнхий хуулийн 26.1.15-д заасан “Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/100 дугаар тушаалаар батлагдаж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6745 дугаарт 2024 оны 3 дугаар сарын 22-ний өдөр бүртгэгдсэн. Энэхүү дүрмээр (i) сургууль хуулийн этгээд болохыг тодорхойлж, суралцагч бүрд тэгш хүртээмжтэй, тэгш боломж олгосон чанартай	100%	100 %

							боловсролын үйлчилгээ үзүүлэх, (ii) суралцагчийн ялгаатай байдал, хувийн онцлог, хэрэгцээг хүндэтгэн авьяас, чадвар, сонирхлыг хөгжүүлэх, тэдэнд туслах, дэмжих үйлчилгээ үзүүлэх, (iii) сургуулийн орчинд хүүхдийн эрхийн зөрчил, үе тэнгийн дээрэлхэл, дарамт, ялгаварлан гадуурхалт, гэмт хэрэг, хорт зуршил, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээ хэрэгжүүлэх, (iv) боловсролын харилцаанд оролцогч талуудын хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх шийдвэр гаргахын өмнө тэдний саналыг заавал авч, хэлэлцэх, баталгаажсан шийдвэрийг мэдээлж байх, мөн сургуулийн хэмжээнд мөрдөх		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							зарим дүрэм, журмын төсөл боловсруулахад тэд оролцох, дагаж мөрддөг байх, (v) холбогдох хууль заасны дагуу сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн байгууллага сургуульд ажиллах, (vi) багш нарын зөвлөл, мэргэжлийн багш нарын бүлгийн хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг болон сургуулийн үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоог тус тус тодорхойлж, (vii) холбогдох хуулиар зөвшөөрсөн төсөв, санхүүгийн мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангах зэрэг асуудлыг зохицуулсан. Хавсралт: 1 файл		
3.1.3	Үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж байгаа төрийн бус өмчийн ерөнхий	-	Гэрээний үр дүнгийн шалгуур	-	Гэрээний үр дүнгийн шалгуур боловсруулсан байна.	-	Боловсролын ерөнхий хуулийн 38.10-т заасныг хэрэгжүүлэхтэй холбогдуулан “Төрийн бус өмчийн	100%	100 %

	боловсролын сургуультай байгуулах гэрээний үр дүнгийн шалгуур боловсруулна.						ерөнхий боловсролын сургуульд улсын төсвөөс хувьсах зардлын санхүүжилт олгох гэрээний үр дүнгийн шалгуур"-ыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 64 дүгээр тушаалаар батлууллаа. Энэ тушаалаар харьяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэх удирдлагатай аймаг, нийслэлийн боловсролын газар жил бүр гэрээ байгуулж, үр дүнд суурилан санхүүжилт олгох, гэрээний гүйцэтгэлийг санхүүгийн жилд хоёр удаа үнэлэхээр тус тус зохицуулсан. Харин үр дүнгийн шалгуур нь үндэсний сургалтын		
--	---	--	--	--	--	--	---	--	--

							хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагчдын монгол хэл, бичиг, унших чадварын түвшин, тэгш хамруулан сургах боловсролыг дэмжих, суралцагчийн сурч боловсрох эрхийг хангах 4 багц асуудлын гүйцэтгэл, үр дүнг хэмжихэд чиглэсэн. Хавсралт: 1 файл		
3.1.4	Цэцэрлэг, сургуулийн зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам боловсруулна.	-	Эрх зүйн актын төсөл, Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал	-	Нийтлэг журам боловсруулсан байна.	-	Боловсролын ерөнхий хуулийн 34.5-д заасан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/158 дугаар тушаалаар батлагдаж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр	100%	100%

							бүртгэгдсэн. Журамд (i) Зөвлөл нь орон тооны бус байх, зөвлөл холбогдох хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, (ii) зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хурал байх, хурлаар Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 23.2, 24.5-д заасан чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэх, хурлын бэлтгэл ажил, хурлын тэмдэглэлд тусгах асуудал, хурлын шийдвэр нь санал, дүгнэлт, зөвлөмж /тогтоол/ хэлбэртэй байх, (iii) зөвлөл үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллах, зөвлөлийн хурлын шийдвэр болон төлөвлөгөөний хэрэгжилтийг зөвлөлийн хурлаар хэлэлцэх, (iv) хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх зорилгоор		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							гишүүдийг багийн зохион байгуулалтаар ажиллуулах, тодорхой асуудлаар үйл ажиллагаандаа туслах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулж болох, (v) Зөвлөлийн бүрэлдэхүүн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар цэцэрлэг, сургуулийн гүйцэтгэх удирдлагатай бичгээр харилцах, тэдний албан үүрэгт хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, эсхүл багш, ажилтны хувийн эрх, нэр төр, ажил хэргийн нэр хүндэд халдах аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргахыг хориглох, (vi) зөвлөлийн хурлын шийдвэр болон бусад мэдээлэл, тайланг талуудад ойлгомжтой байдлаар		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							мэдээлэх. Зөвлөлийн гишүүдэд Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 24.6-д заасан дэмжлэгийн хүрээнд урамшуулал олгож болох зэрэг асуудлыг тусгалаа. Мөн энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан үүсгэн байгуулагчийн төлөөллийг хангах, Зөвлөлийн бүрэлдэхүүн сонгох, зөвлөлийг дундын хэлбэрээр байгуулах асуудлаар “ЗӨВЛӨМЖ” боловсруулж, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ны 2/1800 дугаар албан бичгээр Боловсролын ерөнхий газар, аймаг, нийслэлийн		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							боловсролын газарт хүргүүлэв. Хавсралт: 2 файл		
3.1.5	Төрөлжсөн сургалтын хөтөлбөрт тавих шаардлага болон нэмэлт зардал, сургалт зохион байгуулах журам боловсруулна.	-	Эрх зүйн актын төсөл, Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал	-	Журмын төслийг боловсруулан хэлэлцүүлсэн байна.	Журмыг батлуулсан байна.	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн "Журам батлах тухай" А/262 дугаар тушаалаар "Төрөлжсөн сургалт зохион байгуулах журам"-ыг баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн бүртгэлд 6844 дугаартай бүртгэгдсэн. Журмын төслийг боловсруулан, хэлэлцүүлэх, сайжруулахад БНБТГ-тай хамтран ажилласан бөгөөд батлагдсан журмыг боловсролын ерөнхий газар, аймгийн БШУГ, Нийслэлийн боловсролын газруудад ЕББУЗГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 5/2449	100%	100%

							дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Хавсралт: 2 файл		
3.1.6	Ерөнхий боловсролын сургуульд зайн болон цахим сургалт зохион байгуулах журам боловсруулна.	-	Эрх зүйн актын төсөл, Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал	-	Журмын төсөл боловсруулсан байна.	Журмыг батлуулсан байна.	Ерөнхий боловсролын сургуульд зайн болон цахим сургалт зохион байгуулах журмыг Боловсролын Дэлхийн Түншлэл (GPE) олон улсын байгууллагын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих" төсөл, АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах" төслийн Хосолсон сургалт бүрэлдэхүүний хүрээнд зохион байгуулах сургалт, нийт 97 сургуульд хэрэгжүүлэх хосолсон сургалтын	50%	50%

							туршилтын үр дүнд үндэслэн 2024 оны сүүлийн хагас жилд төслийн багтай хамтран боловсруулна. Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих" төсөл нь ЕБ-ын 50 сургуульд, "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах" төслөөс ЕБС-ийн 47 сургууль тус тус хосолсон сургалтын орчин бүрдүүлэн багш нарт сургалтын үе шаттай зохион байгуулж байна.		
3.1.7	ЕБС-ийн хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр боловсруулж, батлуулна	-	Үлгэрчилсэн хөтөлбөр, баталсан тушаал	БШУ-ны сайдын 2022 оны А/288 дугаар тушаал	Үлгэрчилсэн хөтөлбөр батлуулсан байна.	-	УИХ-ын 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/26 дугаар тушаалаар "Ерөнхий	100%	100%

							боловсролын сургуулийн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны үлгэрчилсэн хөтөлбөр"-ийг батлуулав. Уг үлгэрчилсэн хөтөлбөрт 8 тэргүүлэх чиглэлийг тодорхойлон, бага, дунд, ахлах ангид хичээлээс гадуурх, сургалт, үйл ажиллагаагаар эзэмшүүлэх ур чадварыг зааж, суралцагчийн сайн дурын үндсэн дээр тэдний сонирхол, хэрэгцээ, багшийн ур чадвар, хүний нөөц, орон нутгийн онцлог зэргийг харгалзан сургууль эсхүл нутгийн захиргааны болон мэргэжлийн байгууллагыг түшиглэн суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийтийн оролцоотой зохион байгуулах зохицуулалтыг тусгалаа. Үүнд: 1)		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							хүүхдийн хөгжил, төлөвшлийг дэмжих, үүрэг оролцоог гэр бүлийн хүрээнд нэмэгдүүлэх, хэрэгжүүлэхэд хамтрах үйл ажиллагаа 2) эрүүл, аюулгүй амьдрах арга ухаанд сургах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ур чадвар эзэмшүүлэх үйл ажиллагаа 3) бие бялдар, авьяас чадвар хөгжүүлэх үйл ажиллагаа 4) мэдээллийн технологийн ёс зүйтэй хэрэглээг дэмжих үйл ажиллагаа 5) суралцагчдын нийгэм, олон нийтийн үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагаа 6) хувь хүний хөгжлийг дэмжих, дэлхийн иргэн байх ур чадвар эзэмшүүлэх 7) эх оронч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих 8) байгаль, экологийн хүмүүжлийг		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							төлөвшүүлэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан. Түүнчлэн уг үлгэрчилсэн хөтөлбөрийн хавсралтад сургууль, дотуур байранд хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагааны загвар хөтөлбөрийг боловсруулж өгсөн нь сургуулийн багш, ажилтнуудад арга зүйн дэмжлэг болох юм. Хавсралт: 1 файл		
3.1.9	Гадаад улсын эсхүл олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын ерөнхий боловсролын сургалтын байгууллагад шилжин суралцах тохиолдолд суралцагчийн эзэмшсэн	-	Эрх зүйн актын төсөл, баталсан шийдвэр-тушаал	-	Эрх зүйн актын төсөл боловсруулсан байна.	Эрх зүйн актыг батлуулсан байна.	Боловсролын ерөнхий хуулийн 9.6-д "Гадаад улсын, эсхүл олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын боловсролын сургалтын байгууллагад шилжин суралцах тохиолдолд суралцагчийн эзэмшсэн	100%	100%

	чадамжийг үнэлж, дүйцүүлэх журам боловсруулна.						чадамжийг үнэлж, дүйцүүлэх, багц цаг тооцох журмыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батлах"-аар заасан. Иймд БЕГ-ын СХХҮХГ-тай хамтран Гадаад улсын эсхүл олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын ерөнхий боловсролын сургалтын байгууллагад шилжин суралцах тохиолдолд суралцагчийн эзэмшсэн чадамжийг үнэлж, дүйцүүлэх журмын төслийг боловсруулсан. Журмын төсөлд Гадаад улсын эсхүл олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							ерөнхий боловсролын сургалтын байгууллагын төгсөх ангид суралцах хүсэлтийг аймаг, нийслэлийн боловсролын газар, бусад ангид шилжин суралцах хүсэлтийг ЕБС тус тус шийдвэрлэхээр, Зарчмын хувьд суралцагч, /хүүхдийн/ эрхийг хүндэтгэн: - Суралцагчийг хуульд заасан тухайн насанд нь тухайн түвшний боловсролыг эзэмшүүлэхийг зорих - Шаардлагатай агуулгын зөрүү арилгах, нөхөн эзэмшүүлэх үйл ажиллагааг ЕБС зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх - БШУГ, БЕГ дээр төвлөрөл ачаалал үүсгэхгүй байх - Гадаадад амьдарч байгаад ирсэн суралцагчид МУ-ын боловсролын үйлчилгээг үзүүлэхдээ гарч		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							болох хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэн ээлтэй хандахыг зорьсон зохицуулалтуудыг тусган боловсруулсан. Хавсралт: 1 файл		
3.1.1 0	Ерөнхий боловсролын сурах бичгийн эх зохиох, санал авах, дүгнэлт гаргуулах, ашиглах үйл ажиллагааны журам боловсруулж батлуулна.	-	Журмын төсөл, баталсан шийдвэр	-	Журам боловсруулж, батлуулсан байна.	-	Сурах бичгийн эх зохиох, дүгнэлт гаргуулах, хэвлэх, түгээх, ашиглах үйл ажиллагааны журмын төслийг боловсруулсан. Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс хоёр удаа тус журмын төсөлд санал авсан. Сурах бичгийн талаар баримтлах бодлого батлагдаагүй байгаа тул сурах бичгийн талаар баримтлах бодлого чиглэлийн талаар БНБТГ-аас хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулсан. Энэ хэлэлцүүлэг дээр яригдсан бодлогын чиглэлийг тусган журмын төслийг	70%	70%

							дахин сайжруулж байна. Журмын төсөлд сурах бичгийн эх зохиох, турших, хэвлэх, дүгнэлт гаргуулах, цахим сурах бичиг гэсэн үндсэн асуудлуудыг тусгасан.		
3.1.1 1	Ерөнхий боловсролын баримт бичгийн загвар, түүнийг хөтлөх, олгох журмыг шинэчлэн батлуулна.	-	Баримт бичгийн шинэчилсэн загвар, хөтлөх, олгох журам, баталсан тушаал	БСШУС-ын сайдын 2019 оны А/156 дугаар тушаал	Суурь, бүрэн дунд боловсролын баримт бичгийн загвар, хөтлөх, олгох журмыг шинэчлэн батлуулсан байна.	-	ЕБС төгсөгчдөд олгох боловсролын баримт бичгийг загвар, түүнийг хөтлөх, олгох журмын төслийг боловсруулсан. Гадаад улсад, эсхүл олон улсын болон гадаад улсын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалтын байгууллагад суралцаж суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн иргэнд тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичгийг олгосон боловсролын баримт бичгийг Монгол улсын ижил түвшний боловсролын	70%	70%

							баримт бичигтэй дүйцүүлэх талаарх зохицуулалтыг энэхүү журамд хамтатган оруулсан. Боловсролын ерөнхий хуулийн 9.2-т заасны дагуу Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчид ГЭРЧИЛГЭЭ олгох тул бүрэн дунд боловсролын ҮНЭМЛЭХ-гэснийг бүрэн дунд боловсролын ГЭРЧИЛГЭЭ гэж өөрчилсөн ба суурь, бүрэн дунд боловсролын баримт бичигт судалсан хичээл болон үнэлгээг бичихээс гадна тухайн хичээлийг судалсан агуулгын багтаамжийг илэрхийлсэн цагийг бичих зэрэг өөрчлөлтүүдийг тусгасан. Учир нь гадаад улсын дараагийн шатны боловсролын сургалтын байгууллагад элсэх иргэний судалсан		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							хичээлийн агуулгын багтаамжийг тодорхойлох нэмэлт тайлбар, тодорхойлолтыг шаардах тохиолдол гардаг тул зарим улс орны боловсролын баримт бичигт болон манай улсын дээд боловсролын баримт бичигт хичээлийг судалсан агуулгын багтаамжийг академик цаг болон багц цагаар илэрхийлэн бичдэг. Мөн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан болон төрөлжүүлэн, сонгон судалсан зарим хичээлийн багц цагийг цагийг их дээд сургуулийн багц цагт шилжүүлэн тооцох хэрэгцээ гарах талтайг харгалзсан болно. Хавсралт: 2 файл		
--	--	--	--	--	--	--	---	--	--

3.1.1 2	Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм, норматив, нэг бүлэгт суралцах хүүхдийн тоог шинэчлэн боловсруулна.	-	норм, норматив	БСШУ-ны сайд, НХХ-ийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237	ЕБС-ийн багшийн ажлын ачаалал, нормативын хэрэгжилтийн судалгаа хийсэн байна.	Норм, нормативыг шинэчлэх хувилбарыг удирдлагад танилцуулсан байна.	Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм, цалин хөлс, ачааллын судалгааг БСҮХ-ээс 2023 онд судалж, тайлан боловсруулсан. Тус судалгаанд үндэслэн Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм, норматив, нэг бүлэгт суралцах хүүхдийн тоог шинэчлэн боловсруулсан. Зарим яамдын саналыг тусгахаар ажиллаж байна. Хавсралт: 1 файл	50%	50%
3.1.1 3	ЕБС-ийн багшаас бусад ажилтны орон тооны жишиг норм нормативыг шинэчлэх хувилбар боловсруулна.	-	Жишиг нормативын шинэчлэх хувилбар төсөл	БСШУС-ын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А/024/11 дүгээр тушаал	Жишиг нормативын төслийг боловсруулж, төсвийн тооцооллыг холбогдох нэгжтэй хамтран хийсэн байна.	Жишиг нормативын төслийг удирдлагад танилцуулсан байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, ажилтны орон тооны жишиг хязгаар, хэрэгжүүлэх заавар, ерөнхий боловсролын сургуулийн дотуур	100%	100%

							байрны ажилтны орон тооны жишиг хязгаар, хэрэгжүүлэх зааврыг тус тус Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар төслийг боловсруулан батлуулахад бэлэн болсон. Төслийг Сангийн яамны холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран эцэслэж, БШУЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүлээлгэн өгсөн. /хавсаргав/ Тус орон тооны хязгаарын жишиг норматив болон хэрэгжүүлэх нийтлэг зааврыг баталснаар ерөнхий боловсролын сургуулиуд нь сургуулийн барилга байгууламжийн хүчин чадал болон хүүхдийн тоог үндэслэн тогтоосон орон тооны дээд		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							хязгаартаа багтаан бүтэц, хүний нөөцөө ажиллуулах юм. Ингэснээр дур мэдэн орон тоогоо нэмэгдүүлэх, өр төлбөр үүсгэх гэх мэт зөрчлүүд арилах, улмаар төсвийн санхүүжилтийн үр ашиггүй байдал буурах эерэг үр дагавартай. Хавсралт: 1 файл		
3.1.1 4	Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтанд мэргэжлийн зэрэг олгох, хүчингүй болгох эрх зүйн актыг шинэчлэн боловсруулна.	-	Эрх зүйн актын төсөл, баталсан шийдвэр	-	Журмын төслийг боловсруулан батлуулсан байна.	Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаалд холбогдох өөрчлөлт оруулах саналыг ХНХЯ-д уламжилж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн байна.	Ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмын төслийг боловсруулж, Боловсрол, шинжлэх ухааны яамны цахим хуудсаар болон яамны холбогдох нэгж, ажилтнуудаас санал авч тусган сайжруулж байна. Журмын төслийг боловсруулахдаа олон улсын жишгийн дагуу багшид тавигддаг	70%	70%

							шаардлага, стандартыг баримжаалан багшийн ёс зүй, манлайлал, ажил мэргэжлийн ур чадвар, сургалтын чанар, мэргэжлийн хөгжил, хамтын ажиллагаа, хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлийн шалгуур үзүүлэлтүүдийг тусган, ерөнхий болон нийтлэг шалгуур, үйл ажиллагааны зохион байгуулалт зэргийг тусгасан. Хавсралт: 1 файл		
3.1.1 5	Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагаа, мэргэжил дээшлүүлэх журмын төсөл, багшийн мэргэжлийн хөгжлийн сургалтын хөтөлбөрт тавих шаардлагын төслийг	-	Эрх зүйн актын төсөл, баталсан шийдвэр	-	Журмыг батлуулсан байна.	Сургалтын хөтөлбөрт тавих шаардлагыг, батлуулсан байна.	Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагаа, мэргэжил дээшлүүлэх журмын төсөл, багшийн мэргэжлийн хөгжлийн сургалтын хөтөлбөрт тавих шаардлагын төслийг боловсруулсан.	50%	50%

	боловсруулж батлуулна.						Хавсралт: 1 файл		
3.1.1 6	Багш, удирдах ажилтны ёс зүйн дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулан батлуулна.	-	Эрх зүйн актын төсөл, батуулсан шийдвэр	БШУ-ны сайдын 2022 оны 545 дугаар тушаал	Журмын төслийг боловсруулан батлуулсан байна.	-	Багш, удирдах ажилтны ёс зүйн дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг БНБТГ-аас боловсруулан санал авч байгаа болно.	30%	30%
3.1.1 7	Багшийн хөгжлийн төвийн ажиллах үлгэрчилсэн журам, тавигдах шаардлагын төсөл боловсруулж батлуулна.	-	Эрх зүйн актын төсөл, баталсан тушаал	-	Журмын төслийг боловсруулан, батлуулсан байна.	-	Багшийн хөгжлийн төвийн ажиллах үлгэрчилсэн журам, тавигдах шаардлагын төсөл боловсруулан, БНБТГ-тай зөвшилцөх шатанд байна. Багшийн хөгжлийн үндэсний төв байгуулахтай холбогдуулан сайжруулах шаардлагатай болсон.	50%	50%
3.1.1 8	Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтныг шилжүүлэн ажиллуулах, хугацаа журмын төсөл боловсруулна	-	Эрх зүйн актын төсөл, баталсан шийдвэр	-	Эрх зүйн актын төсөл боловсруулсан байна.	Эрх зүйн актыг батлуулсан байна.	“Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, удирдах ажилтныг	70%	70%

							шилжүүлэн ажиллуулах журам”-ын төслийг боловсруулж, 2023 оны 11 дүгээр сарын 02-н өдөр Боловсрол, шинжлэх ухааны яамны цахим хуудасд байршуулан нээлттэй санал авч, ирсэн саналуудыг тусган дахин боловсруулсан хувилбарыг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр БШУЯ-ны нэгжүүд, холбогдох албан тушаалтнуудаар 111 тоотод хэлэлцүүлж санал авч тусгасан. Хавсралт: 1 файл		
3.1.1 9	ЕБС-ийн ахлах ангид “Багш мэргэжлийн сонгон бүлэг хичээллүүлэх журам” болон сургалтын хөтөлбөрт тавих шаардлагын төслийг боловсруулж, хэлэлцүүлнэ.	-	Эрх зүйн актын төсөл	-	Эрх зүйн актын төсөл боловсруулсан байна.	Эрх зүйн актын төслийг хэлэлцүүлсэн байна.	Тодорхой ажил хийгдээгүй.	30%	30%

Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ

4.1.	Төрийн албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж, хамтран ажиллах	-	Өргөдөл, гомдол, албан бичгийн шийдвэрлэлт	-	90		ЕББУЗГ-т 66 албан бичиг ирснээс 59 нь хариутай, үүнээс шийдвэрлэгдсэн 55 буюу 93.22%, Иргэдээс бичгээр болон Засгийн газрын олон нийттэй харилцах 11-11 төвөөс хуваарилагдан ирсэн нийт 209 өргөдөл, гомдол байгаагаас шийдвэрлэгдсэн 208 /99,52%/ байна.	100%	100 %
4.1.1	Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу иргэд, албан тушаалтан, төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, хүсэлт, санал гомдлыг шийдвэрлэх, хуулийн хугацаанд хариу өгөх.	-	Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу иргэд, албан тушаалтан, төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, хүсэлт, санал гомдлыг шийдвэрлэх, хуулийн хугацаанд хариу өгөх	-	Албан бичиг, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн, хариу өгсөн байна.	Албан бичиг, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн, хариу өгсөн байна.	ЕББУЗГ-т 2024 оны эхний хагаст нийт 66 албан бичиг ирснээс 59 нь хариутай, үүнээс шийдвэрлэгдсэн 55 буюу 93.22%, хяналтад байгаа 3, хугацаа хэтэрсэн 1 бичиг байна. Хугацаа хэтэрсэн бичгийн шалтгаан нь ЗГ-ын тогтоолын төсөл боловсруулан яамдаас санал авахтай холбоотойгоор хэтэрсэн байна. Иргэдээс бичгээр	100%	100 %

							болон Засгийн газрын олон нийттэй харилцах 11-11 төвөөс хуваарилагдан ирсэн нийт 209 өргөдөл, гомдол байгаагаас шийдвэрлэгдсэн 208 /99,52%/, судлагдаж байгаа 1, хугацаа хэтэрсэн өргөдөл гомдол байхгүй байна. Хавсралт: 1 файл		
4.1.2	Удирдах албан тушаалтан, холбогдох байгууллагаас шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг шуурхай, чанартай, гаргаж өгөх	-	Мэдээлэл, судалгаа, тайлангийн чанар, хугацаа	-	Удирдах албан тушаалтан, холбогдох байгууллагаас шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг шуурхай, чанартай, гаргаж өгөх	Удирдах албан тушаалтан, холбогдох байгууллагаас шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг шуурхай, чанартай, гаргаж өгөх	Удирдах албан тушаалтан, холбогдох байгууллагаас шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг шуурхай, чанартай, гаргаж ажиллаж байна. Тухайлбал: 1. Олон улсын хөтөлбөр хэрэгжүүлж буй төрийн өмчийн ЕБС-ийн 2023 оын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсэгт ажиллав. Ажлын хэсэг нь Шинэ эрин, Шинэ эхлэл,	100%	100 %

							Монгол тэмүүлэл 3 сургуулийн 2023 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, тус сургуульд хэрэгжүүлж буй үндэсний болон олон улсын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, багшлах хүний нөөц, санхүү төсвийн хуваарилалт, зарцуулалт, сургуулийн удирдлага, зохион байгуулалтад иж бүрэн шинжилгээ хийж, тайлан, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж ажиллалаа. 2. БШУЯ-аас албан ёсны зөвшөөрөлтэйгээр олон улсын хөтөлбөр хэрэгжүүлж буй төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 22 сургуульд		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							төлөвлөгөөт бус хяналт, шалгалт хийх ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ЕББУЗГ-ын 2 ажилтан ажиллаж, үндэсний хөтөлбөр, олон улсын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, багшлах хүний нөөцийн хангалт, сургалтын төлбөр тогтоосон үндэслэл зэргийг хянан шалгасан ажлын хэсгийн дүгнэлтийг нэгтгэн боловсруулж, танилцуулга, хяналт, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулав. 3. Сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай болон энгийн зөвшөөрөл авах, сунгуулах хүсэлт ирүүлсэн 14 сургуулийн бичиг баримтыг www.license.mn систем дээр хянасан. 4. ХЭҮК-оос ЕБС-ийн		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							сургалтын хөтөлбөрт хүний эрх, жендэрийг агуулга тусгагдсан байдал, Бүх түвшний сургалтын хөтөлбөр, засаглал, оютны оролцооны байгууллага, Боловсролын салбарын тогтолцоо, эрх зүйн баримт бичгүүдэд хүний эрх, жендэрийн агуулга, үйл ажиллагааг тусган зохицуулсан талаарх мэдээлэл /45 хуудас / зэргийг бэлтгэн БШУ-ны сайд, ТНБД-ын албан бичгээр, 5. "Бүх нийт боловсролын төлөө" ИНҮЭ-ээс үндэстний цөөнхий суралцагчдын сурч боловсрол эрхийг хангах чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээлэл хүссэний дагуус НБД-ын албан бичгээр хүргүүлэв.		
4.1.3	Төрийн болон Төрийн бус	-	Хамтын ажиллагааны	-	Шаардлагатай хамтын	Шаардлагатай хамтын	1. БШУЯ-ны ЕБ-ын салбарт хэрэгжүүлж	100%	100 %

	байгууллага, иргэдтэй эрхэлсэн ажлын чиглэлээр хамтран ажиллаж, зөвлөгөө, мэдээлэл өгнө.		тайлан, мэдээлэл		ажиллагааны санамж бичиг, гэрээ, тайлан мэдээллийг цаг хугацаанд нь боловсруулж, хэрэгжүүлсэн байна	ажиллагааны санамж бичиг, гэрээ, тайлан мэдээллийг цаг хугацаанд нь боловсруулж, хэрэгжүүлсэн байна	буй төслүүд, Багшлахуйн баясгалан ТББ, Уншигч ТББ, Стем Брайны Тэч ТББ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, холбогдох гэрээ, төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулж, албажуулж ажиллалаа. 2. Сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай болон энгийн зөвшөөрөл авах, сунгуулах хүсэлтийг ирүүлсэн 14 сургуулийн бичиг баримтыг www.license.mn систем дээр хянаж, шийдвэрлэн, шаардлага хангасан сургалтын байгууллагад зөвшөөрөл олгох шийдвэрийг албажуулсан. 3. Албан өрөөний утас, биеэр ирж хандсан иргэд, ТББ, аж ахуйн нэгжийн асуулт, санал, хүсэлтийг тухай бүрд шийдвэрлэн хамтран		
--	--	--	------------------	--	---	---	--	--	--

							ажиллалаа. 4. ХЭҮК-оос ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт хүний эрх, жендэрийг агуулга тусгагдсан байдал, Бүх түвшний сургалтын хөтөлбөр, засаглал, оюутны оролцооны байгууллага, Боловсролын салбарын тогтолцоо, эрх зүйн баримт бичгүүдэд хүний эрх, жендэрийн агуулга, үйл ажиллагааг тусган зохицуулсан талаарх мэдээлэл /45 хуудас / зэргийг бэлтгэн БШУ-ны сайд, ТНБД-ын албан бичгээр, 5. "Бүх нийт боловсролын төлөө" ИНҮЭ-ээс үндэстний цөөнхийн суралцагчдын сурч боловсрол эрхийг хангах чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээлэл хүссэний дагуу ТНБД-ын		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							албан бичгээр хүргүүлэв.		
4.1.4	Ерөнхий боловсролын салбарын богино, дунд хугацааны төлөвлөгөө, удирдамж, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд мэргэжлийн байгууллага, БШУЯ-ны бусад нэгж, ажлын хэсэгтэй хамтран ажиллах	-	Ажлын хэсэгт гүйцэтгэсэн үүрэг, удирдамж, төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн	-	Мэргэжлийн байгууллага, нэгж хоорондын хамтын ажиллагаа, ажлын хэсгийн төлөвлөгөө, удирдамжийг хэрэгжүүлж ажилласан байна.	Мэргэжлийн байгууллага, нэгж хоорондын хамтын ажиллагаа, ажлын хэсгийн төлөвлөгөө, удирдамжийг хэрэгжүүлж ажилласан байна.	1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын баталсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарт 2023-2024 оны хичээлийн жилд дэвшүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилтийн тайланг аймаг, нийслэлийн боловсрол, шинжлэх ухааны газруудаас цуглуулж, шинжилгээ хийлээ. 2. Ерөнхий боловсролын салбарын богино, дунд хугацааны төлөвлөгөө, удирдамж, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд мэргэжлийн байгууллага, БШУЯ-ны бусад нэгж, ажлын хэсэгтэй хамтран ажиллаж байна. Үүнд: 1. ЭМЯ-тай хамтран Иргэний эрүүл мэндийн	100%	100%

							боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, Эрүүл мэндийн сайд, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/75/09/73/34 дүгээр хамтарсан тушаалаар батлуулсан. 2. БШУЯ-ны бусад нэгжээс дотоод бичгээр ирүүлсэн төлөвлөгөө, хөтөлбөр, дүрэм журмын төсөлд нэгжийн хэмжээнд санал авч, нэгтгэн хүргүүлж байна. 3. Мэргэжлийн байгууллагуудаас ирүүлсэн албан бичгийн дагуу дүрэм, журмыг хэрэгжүүлэх чиглэл, зохицуулалтыг нэгжийн дарга, ТНБД, сайдын		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							албан бичгээр хариу өгч, зохицуулалтаар хангаж ажиллаж байна. 5. Нэгжийн сар, улирал, хагас жил, жилийн тайлан төлөвлөгөөг цаг хугацаанд нь нэгтгэн боловсруулж, тайлагнаж байна. 6. 2024 оны эхний хагас жилд БШУЯ-ын нэгжүүдээс ТХСБХ, ХШҮДАГ, СХГ-тай түлхүү хамтран ажиллалаа. Тухайлбал олон улсын хөтөлбөр хэрэгжүүлж буй төрийн өмчийн 3 ЕБС-д аудит хийж, тайлан дүгнэлт боловсруулсан. Төрийн бус өмчийн, олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх тусгай зөвшөөрөлтэй ЕБС-ийн бичиг баримтад шинжилгээ хийх, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхэд ЕББУЗГ-ын мэргэжилтнүүд хамтран ажиллаж,		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							тайлан мэдээг боловсруулсан.		
--	--	--	--	--	--	--	---------------------------------	--	--

Үнэлсэн:

.....

.....

...../...../

(албан тушаал)

(гарын үсэг)

.....

(огноо)

Тайлагнасан:

.....

.....

...../...../

(албан тушаал)

(гарын үсэг)

.....

(огноо)